


# ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС (2015-02 САР)

Монголбанк, “Тэнхлэг зууч” компанитай хамтран 2015 оны 2 дугаар сарын “Орон сууцны үнийн индекс”-ийг тооцоолон, танилцуулж байна. Энэхүү тооцоо, судалгаанд тухайн сард зах зээлд нийлүүлэгдсэн шинэ, хуучин 4068 орон сууцны үнийг хамруулсан болно.

## ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС


2015 оны 2 дугаар сарын байдлаар орон сууцны үнэ өмнөх сараас 0.5%, өнгөрсөн оны мөн үеэс 5.1%, сүүлийн 7 сард 6.3% буюу сард дунджаар 0.9%-иар буурсан байна.

ЗУРАГ 1: УЛААНБААТАР ХОТЫН ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКС /2013.01=1.00/



Шинэ орон сууцны үнийн бууралт харьцангуй бага, хуучин орон сууцны үнэ хурдтай буурч байгаа нь орон сууцны үнэ сүүлийн 7 сар дараалан буурахад нөлөөлжээ.

ЗУРАГ 2: ОРОН СУУЦНЫ ҮНИЙН ИНДЕКСИЙН ЖИЛИЙН ӨСӨЛТ /2013.01=1.00/



2013 оны 1 дүгээр сараас эхлэх орон сууцны үнийн индексийг тооцсон бөгөөд орон сууцны үнийн жилийн өсөлт 2014.3 сард хамгийн өндөр буюу 23.7%-д хүрч байсан бол 2014.4 дүгээр сараас эхлэн өсөлт нь саарч, улмаар өмнөх оны мөн үеэс орон сууцны үнэ буурчээ.

Жишээ: “Алтай” хотхонд 2014.7 сард 1 м<sup>2</sup> дундаж үнэ 2,172,513 төгрөг байсан бол 2015.2 сарын байдлаар 2,025,176 төгрөг болж 6.8%-иар буурсан байна.


## 1. Шинэ орон сууцны үнэ<sup>1</sup>

Шинэ орон сууцны 1м.кв дундаж үнэ нь 2015 оны 2 дугаар сарын байдлаар 2,157,300 төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 2.3 хувиар буурсан дүнтэй байна.

ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ-ИЙН ДУНДАЖ ҮНЭ /2015.02/


|                        |                  |
|------------------------|------------------|
| Орон сууцны дундаж үнэ | 2,157,300 төгрөг |
| Жилийн өсөлтийн хувь   | -2.3%            |
| Сарын өсөлтийн хувь    | -0.2%            |
| Хамгийн өндөр үнэтэй   | Сүхбаатар        |
| Хамгийн бага үнэтэй    | Сонгино хайрхан  |

ЗУРАГ 3: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /сая.төгрөг/



Сүхбаатар дүүрэгт шинэ орон сууцны 1м.кв-ийн дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Сонгино хайрхан дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 4: ШИНЭ ОРОН СУУЦНЫ 1 М.КВ ДУНДАЖ ҮНЭ /САЯ ₮/




## 2. Хуучин орон сууцны үнэ – 2 өрөө байр

Хуучин 2 өрөө байрны дундаж үнэ<sup>2</sup> нь 2015 оны 2 дугаар сарын байдлаар 95,950,000 төгрөг болж өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 6.6 хувиар буурсан дүнтэй байна.

ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /2015.02/


|                        |                   |
|------------------------|-------------------|
| Орон сууцны дундаж үнэ | 95,950,000 төгрөг |
| Жилийн өсөлтийн хувь   | -6.6%             |
| Сарын өсөлтийн хувь    | -1.9%             |
| Хамгийн өндөр үнэтэй   | Сүхбаатар         |
| Хамгийн бага үнэтэй    | Хан-Уул           |

ЗУРАГ 5: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ /САЯ ₮/



Сүхбаатар дүүрэгт хуучин 2 өрөө байрны дундаж үнэ хамгийн өндөр байгаа бол Хан-Уул дүүрэгт хамгийн бага байна.

ЗУРАГ 6: ХУУЧИН 2 ӨРӨӨ БАЙРНЫ ДУНДАЖ ҮНЭ, ДҮҮРЭГ /САЯ ₮/



Эх сурвалж: “Тэнхлэг зууч” компанийн сар бүрийн тооцоолол

<sup>1</sup> Байрны гэрчилгээ нь гараагүй бол шинэ орон сууц.

<sup>2</sup> 2000 оноос өмнөх хуучин орон сууцны үнэ (дүүргүүдийн дундаж үнэ)